

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ “УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ” ХК
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ
(2026 оны эхний хагас жилийн байдлаар)

2026 оны 06 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн:

Шийдвэрийн төрөл	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг	2	2
Засгийн газрын тогтоол	2	2
Засгийн газрын албан даалгавар	1	2
Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол	1	1
Нийслэлийн Засаг даргын захирамж	1	1
Нийт	7	8

Нийт 7 хууль тогтоомжийн 8 заалтын биелэлтийг нэгтгэн Монгол улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын 6.2-д заасан аргачлалаар дүгнэсэн.

Биелэлтийн нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.1.9 дэх заалтад тусгагдсан ажлын гүйцэтгэлийн хувийг тооцох боломжгүй байгаа тул “хэрэгжих шатанд” удаашралтай (эрчимжүүлэх шаардлагатай) буюу 50% хүртэл үнэлгээнд хамруулж үнэлсэн.

Үнэлгээ		Заалтын тоо
Хэрэгжсэн	100	6
Хэрэгжсэн	90	1
Хэрэгжээгүй	40	1
Хэрэгжилтийн дундаж дүн	91.2%	8

ТАНИЛЦСАН:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Э.БҮТЭД-ЭРДЭНЭ
ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГА Г.СҮНЖИДМАА
ҮНЭЛГЭЭ ГАРГАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН
АЖИЛТАН Ц.ДУНГАРМАА

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ “УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ” ХК-ИЙН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7
58	2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр	Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн чиглэл, хуваарийн дагуу 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Бямба гаригт Сонгинохайрхан дүүрэгт байрлах Агропарк 55 ширхэг нарс модны суулгах ажилд нийт 18 албан хаагч хамрагдаж, өгсөн зааварчилгааны дагуу суулгаж тухайн байгууллагын холбогдох ажилтанд хүлээлгэн өгсөн.	100%	
44	1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг	Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гарагуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласугай			
	2	Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр	Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.			
119	4	МУ-ын ЗГ-ын тогтоол Төрийн байууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр	Төрийн байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй, шуурхай байдлыг алдагдуулахгүйгээр Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас цахим сүлжээгээр ажиллуулах, ажлын цагийг уян хатан	Хөдөлмөрийн тухай хууль болон ЗГ-ын 2026 оны 119 дүгээр тогтоол, НЗД-ын 2026 оны А/564 дүгээр захирамжийн хүрээнд Хөдөлмөрийн дотоод журам болон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд холбогдох өөрчлөлтийг оруулан батлуулж, 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 7 хоног бүрийн ажлын 1 өдрийг цахимаар ажиллах, ажил эхлэх цагийг 07.00-08.30, дуусах цагийг 16.00-17.30 цаг байхаар зохицуулсан. Цахимаар ажиллаж буй	100%	

1	2	3	4	5	6	7
			байх дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах, хуульд зааснаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын өдрүүд болон долоо хоногийн амралтын өдрүүдэд ажиллуулахгүй байхыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	өдрийн ажлын цагийн бүтээмж, гүйцэтгэлд холбогдох нэгжийн удирдлага тухай бүр хяналт тавьж, үр дүнг Ерөнхий менежерт сар бүр танилцуулж ажилладаг.		
	1.2	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр	Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;	ЗГ-ын энэхүү шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ТУЗ-ийн 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор бүтэц орон тоог шинэчилж, нийт 26 албан хаагчтай байхаар баталсан бөгөөд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 21 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. (нотлох баримт хавсралтаар оруулсан).	100%	
04	1.3		иргэддээ чин шударгаар үйлчилдэг, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад;	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааны хүрээнд: 1."Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Гүйцэтгэх захирлаар батлуулж, төлөвлөгөөний дагуу "Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг Авилгатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж, 18 албан хаагч хамрагдсан. Мөн Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан Авилгыг мэдээлэх 110 тусгай дугаар 11-10 болон өөрчлөгдсөн мэдээллийг постер хэлбэрээр нийслэлийн "ERP.ulaanbaatar.mn" систем болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэн сурталчилсан. 2."Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага" сэдэвт сургалтыг 2026 оны 3 дугаар сарын 03- ны өдөр зохион байгуулсан ба сургалтаар албан хаагчдад харилцааны мөн чанар, тактик, бусадтай	100%	

1	2	3	4	5	6	7
				харилцах эв дүй мөн төрийн үйлчилгээ, түүний шалгуур үзүүлэлт, хоорондын уялдаа холбооны талаар мэдлэгийг олгосон. (нотлох баримт хавсралтаар оруулсан).		
	1.4		төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцээн байгуулж ажиллуулахыг бүх шатны төрийн байгууллагын удирдлагад;	Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар Ажилтны баримтлах ёс зүйн дүрмийг баталж, Ёс зүйн дэд хороог 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/42 дугаар тушаалаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, төлөвлөсөн 3 арга хэмжээнээс 2 арга хэмжээг хэрэгжүүлсэн. (нотлох баримт хавсралтаар оруулсан).	90%	
41	2	МУ-ын ЗГ-ын тогтоол Журмыг шинэчлэн батлах тухай 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр	Журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.	"Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж, иргэд олон нийтэд төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Шилэн дансны мэдээллийг https://shilendans.gov.mn цахим системд хуулийн хугацаа буюу 2026 оны 03 дугаар сарын 31-ны дотор байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээлэл оруулсан тайлангийн үнэлгээ 50% ба өмнөх онтой харьцуулахад 35 хувиар өссөн байна. Энэхүү системд тайлангийн хугацаанд байгууллагын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд гарсан шийдвэр, орлого зарлага, худалдан авалтын 95 мэдээ байршуулахаас 65 мэдээг байршуулсан.	100%	
25/112	2.1.9	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол "Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай"	Хан-уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй Спорт цогцолборын спортын барилгыг үргэлжлүүлж ашиглалтад оруулах	"Спорт цогцолборын спортын барилгын нэмэлт ажил"-ын тендер шалгаруулалтыг 2026 оны 05 дугаар сарын 08-нд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хариуцан зохион байгуулсан бөгөөд 2 оролцогч талуудын тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй тул цуцлагдсан.	40%	
А/374	1	Нийслэлийн Засаг даргын захирамж	"Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлын гэрээг цуцалж, дүгнэх, акт үйлдэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх, эрчимжүүлэх, санал, дүгнэлт гаргах;	Нийслэлийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу "Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй "Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлын гэрээг цуцалж, дүгнэх, акт үйлдэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх, эрчимжүүлэх, санал, дүгнэлт гаргах" зорилгоор	100%	

1	2	3	4	5	6	7
				Нийслэлийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/374 дүгээр захирамжаар Ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсэг нь барилгын ажлын нөхцөл байдалтай танилцаж, 5 удаа хуралдаж, хурлаас гарсан шийдвэрийг тэмдэглэл хөтөлж баталгаажуулж, улмаар гарсан санал, дүгнэлтийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж, түүнийг үндэслэн "ӨВМТХ" ХХК-тай байгуулсан "Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлын гэрээг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр цуцалж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн. Ажлын хэсгээс гарсан санал дүгнэлт, шийдвэрийг Нийслэлийн Засаг даргад 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр танилцуулж, тайлагнасан.		
Хэрэгжилт				91.2%		

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

Э.БҮТЭД-ЭРДЭНЭ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Ц.ДУНГАРМАА

НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖИЛТАН

Г.ГАНБАЯР

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ “УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ” ХК
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ХАНГАСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2026 оны 06 дугаар сарын 08

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Биелэлт	Хувь
1	2	3	4	5
1	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх;	2026.06.25 2026.12.20	Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дараах хяналт-шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд улирал бүр хяналт-шинжилгээ хийж байгаа бөгөөд эхний хагас жилийн байдлаар байгууллагын чиг үүрэгт хамаарал бүхий нийт 9 шийдвэрийн 10 заалтын хэрэгжилтийг тайлагнасан ба үүнээс 100% хэрэгжилттэй 8, 90% хэрэгжилттэй 1, эрчимжүүлэх шаардлагатай 40%-иар 1 шийдвэр буюу нийт 10 шийдвэрийн хэрэгжилтийг 93 хувиар үнэлэж, үнэлгээний хуудсыг удирдлагад танилцуулсан.	93%
2	Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаварыг бүрэн хэрэгжүүлж, заасан хугацаанд тайлагнаж ажиллах;	2026.03.27 2026.12.20	Нийслэлийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу “Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй “Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын “Спортын төвийн барилга”-ын ажлын гэрээг цуцалж, дүгнэх, акт үйлдэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх, эрчимжүүлэх, санал, дүгнэлт гаргах” зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/374 дүгээр захирамжаар Ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсэг нь барилгын ажлын нөхцөл байдалтай танилцаж, 5 удаа хуралдаж, хурлаас гарсан шийдвэрийг тэмдэглэл хөтөлж баталгаажуулж, улмаар гарсан санал, дүгнэлтийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж, түүнийг үндэслэн “ӨВМТХ” ХХК-тай байгуулсан “Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын “Спортын төвийн барилга”-ын ажлын гэрээг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр цуцалж, гэрээ дүгнэсэн акт үйлдсэн. Ажлын хэсгээс гарсан санал дүгнэлт, шийдвэрийг Нийслэлийн Засаг даргад 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр танилцуулж, тайлагнасан.	100%
3	Төрийн албаны зөвлөлийн 521 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын хувийн хэрэгт шаардлагатай баримт бичгүүдийг хавсаргаж, бүрдлийг хангаж ажиллах;	2026.03.27 2026.06.30	Зөвлөмжийн дагуу нийт 23 албан хаагчийн хувийн хэргийг нэг бүрчлэн нягтлан шалгаж, ТАЗ-ийн 521 дүгээр тогтоолын хавсралт жагсаалтын дагуу хувийн хэрэгт шаардлагатай баримт бичгүүдийн хавсаргаж, бүрдлийг хангаж ажилласан.	100%
4	Байгууллагын албан хаагчдын “Сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”,	2026.03.27 2026.12.20	“Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөг батлах тухай” А/7 дугаар	62.9%

1	2	3	4	5
	төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх;		тушаалыг гүйцэтгэх захирлаар 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу энэ оны эхний хагас жилд нийт 4 зорилтын 14 арга хэмжээг төлөвлөснөөс 7 арга хэмжээний биелэлтийг 62.9 хувиар үнэлж, хийгдээгүй болон сүүлийн хагас жил хийх 7 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзээд үнэлгээнээс хасаж тооцсон.	
5	Хүний нөөцийн бодлогын хүрээнд албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтанд хамруулах	2026.03.27 2026.12.20	Тайлангийн хугацаанд албан хаагчид чадавхижуулах болон мэргэшүүлэх нийт 7 сургалтанд хамрагдсан. Үүнд: 1.Харилцаа хандлага, ёс зүй-2 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 39 албан хаагч 2.Архив, албан хэрэг хөтлөлт-3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 54 албан хаагч 3.Мэргэшүүлэх сургалтад: -Сошиал медиа контентын багц сургалтанд 3 албан хаагч -Санхүүгийн суурь мэдлэгээ дээшлүүлэх "Тод санхүү академи"-н няравын чадавхжуулах сургалтад 1 албан хаагч буюу давхардсан тоогоор нийт 97 албан хаагч хамрагдсан.	100%
6	Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, баримт бичгийн MNS 5140-2021 стандартад мөрдүүлэх;	2026.03.27 2026.12.20	Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт албан хаагчдын чадавхижуулах сургалтыг 3 удаа зохион байгуулснаар албан хаагчдын мэдлэг чадвар дээшилж, улмаар албан бичгийн найруулга зүй, зөв бичгийн дүрмийн алдааны зөрчлийг арилгаж, боловсруулалтын хяналтыг сайжруулсан.	100%
7	Албан бичгийн шийдвэрлэлтийг сайжруулж, шийдвэрлэлтийн хугацааг бууруулах;	2026.03.27 2026.12.20	Албан бичгийн шийдвэрлэлтийг сайжруулахын тулд 2 удаа хяналт-шинжилгээ хийж, илтгэх хуудсаар нэгжийн дарга, Ерөнхий менежерт танилцуулж, албан хаагчид ирсэн бичгийн шийдвэрлэлтийг сайжруулж, шийдвэрлэлтийн хоногийг бууруулах чиглэлээр Нийслэлийн Архивын газартай хамтран албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системийн үйл ажиллагааны сургалт зохион байгуулж, арга зүйн заавар өгсөн.	90%
8	Байгууллагын бизнес болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хэрэгжилтийн тайлагнах;	2026.03.27 2026.12.20	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн анхдугаар хурлын 01 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны зардал, тухайн онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, төсвийг баталсан. Эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагааны зардал (1,141,717.8 мянган мөнгөн төгрөг)-ын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 5-ны дотор гарган баталгаажуулсан.	100%
9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн	2026.03.27 2026.12.20	Байгууллагын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд Гүйцэтгэх захирлаар батлуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn), нийслэлийн Худалдан авах	100%

1	2	3	4	5
	хүрээнд төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнах		ажиллагааны газрын "Худалдан авах ажиллагааны мэдээний цахим систем"-д тус тус байршуулж, харьцуулалтын аргаар 1 тендер шалгаруулалт, 6 шууд худалдан авалтыг тус тус хийж ажилласан.	
10	Шалгарсан болон шалгараагүй тендерийн баримт бичгийн бүрдлийг хангаж, хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт шилжүүлэх;	2026.03.27 2026.12.20	Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй "Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлын А блокийн хучилтын зураг төсөл дахин боловсруулах үйлчилгээний тендер шалгаруулалтын баримт бичиг ("Хаусконстракшн" ХХК нэг компани оролцож, шалгарсан)-ийн бүрдлийг ханган 2025 оны ХХНЖ-ын дагуу цахим болон цаасан хэлбэрээр хадгаламжийн нэгж бүрдүүлж, батлагдсан хуваарийн дагуу байгууллагын архивд жагсаалтаар шилжүүлсэн.	100%
11	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд анхан шатны баримтын бүрдлийг хангасны үндсэн дээр төлбөр тооцоог гүйцэтгэх;	2026.03.27 2026.12.20	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын батлагдсан төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийн анхан шатны баримтын бүрдлийг ханган Татварын ерөнхий газрын (ebarimt.mn) цахим системээр 58 нэхэмжлэх үүсгүүлж, үүссэн нэхэмжлэхийг төлбөрийн баримт болгож, нийт 463,590 мянган төгрөгийн 271 төлбөрийн баримтыг бүрдүүлж, худалдан авалт, ажил үйлчилгээтэй холбоотой гэрээ, гэрээ дүгнэсэн акт, зарлагын баримт, Сангийн сайдын батлагдсан маягт, загварын дагуу бусад холбогдох баримтыг бүрдлийг хангаж ажилласан.	100%
12	Аудитын зөвлөмжийн дагуу илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг заасан хугацаанд тайлагнах;	2026.03.27 2026.12.20	Нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан "Өөрчлөлтгүй" дүгнэлт гарсан. Дүгнэлтийн хүрээнд 2 зөвлөмж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага ирүүлсний дагуу зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Гүйцэтгэх захирлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд заасан хугацаанд тайлагнаж ажиллана. (2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор)	50%
13	Байгууллагын албан ёсны цахим хуудас дахь мэдээллийг тухай бүр шинэчилж олон нийтэд сурталчилах	2026.03.27 2026.12.20	Мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд байгууллагын цахим хуудаст чиг үүрэгтэй холбогдолтой шийдвэрүүдийг нэмж оруулснаас гадна "usm".mn цахим хуудас болон "ERP.ulaanbaatar.mn" системд нийт 13 удаагийн мэдээ, мөн нийслэлд үйл ажиллагаа явуулдаг спортын 90 секц клубын мэдээллийг байршуулж баяжилт хийсэн. Үүнээс гадна байгууллагын "Улаанбаатар спорт менежмент" ХК пэйж хуудсыг нээж, байгууллагаас хийгдсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан ажиллаж байна.	100%
14	Шилэн дансны мэдээллийг https://shilendans.gov.mn цахим системд заасан хугацаанд байршуулж, мэдээллийн зөв, иж бүрэн байдлыг хангаж ажиллах;	Улирал, сар бүр	"Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж, иргэд олон нийтэд төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Шилэн дансны мэдээллийг https://shilendans.gov.mn цахим системд хуулийн хугацаа буюу 2026 оны 03 дугаар сарын 31-ний дотор байгууллагын үйл ажиллагааны болон	70%

1	2	3	4	5
			санхүүгийн мэдээлэл оруулсан тайлангийн үнэлгээ 55% ба өмнөх онтой харьцуулахад 35 хувиар өссөн байна. Энэхүү системд тайлангийн хугацаанд байгууллагын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд гарсан шийдвэр, орлого зарлага, худалдан авалтын 95 мэдээ байршуулахаас 65 мэдээг байршуулсан.	
	Хэрэгжилт		14 арга хэмжээ-90.4%	

ТАНИЛЦСАН:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦСАН
АЖИЛТАН

Э.БҮТЭД-ЭРДЭНЭ

Г.СҮНЖИДМАА

Ц.ДУНГАРМАА